**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/08/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Гантулга<br>Утас: 99439613<br>Цахим хаяг: gantulgats@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ................................ Error! Bookmark not defined.**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ................................ 5**

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ................................ 11**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ................................ 11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ................................ 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ................................ 12

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ................................ 12

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ................................ 13

**3.5.1 Төсвийн төлөвлөлт ................................ 13**

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл ................................ 13**

**3.5.3 Нэмэлт төсөв ................................ 13**

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ................................ Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН ................................ 14**

**4.1 Ерөнхий зүйл ................................ 14**

**4.2 Материаллаг байдал ................................ 14**

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ................................ 14**

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................................ 14**

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ................................ 15**

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ................................ 15**

**4.5.1 Завсрын аудитын талаар ................................ Error! Bookmark not defined.**

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ................................ 15**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ................................ 15

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ................................ 15**

5.1 Залруулсан алдаа ................................ **Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

**ХОВД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 2/72
танай ____________-ны №____________-т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГОМБОСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Монгол Улсын Шадар сайдын багц болон үндсэн үйл ажиллагааны орлогоосоо санхүүждэг бөгөөд 2022 онд улсын төсвөөс 148.6 сая төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанаас 59.5 төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 101.2 хувьтай хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны А/20 дугаар тушаалаар хэрэгжилтийг 91.1 хувьтай үнэлсэн байна.

02102026

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,465,012.00** | **35,464,328.00** |
| **33** | **АВЛАГА** | 25,790,928.00 | 25,390,928.00 |
| **335** | **Бусад авлага** | 25,490,928.00 | 25,390,928.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 100,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 25,390,928.00 | 25,390,928.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 14,674,084.00 | 10,073,400.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 477,949.00 | 465,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 477,949.00 | 465,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 14,196,135.00 | 9,608,400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,061,880.00 | 2,356,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,747,755.00 | 6,201,900.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,386,500.00 | 1,050,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **301,521,492.37** | **376,430,464.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 301,521,492.37 | 376,430,464.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 294,321,492.37 | 369,021,464.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 294,612,490.00 | 294,612,490.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -16,667,526.28 | -22,669,767.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 154,945,526.00 | 100,181,980.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -142,406,776.22 | -10,276,250.34 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,634,399.30 | 5,811,450.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,428,939.57 | -2,054,115.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,609,630.00 | 4,401,630.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -977,310.86 | -985,952.86 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,200,000.00 | 7,409,000.00 |
| 39301 | Програм хангамж | 772,500.00 | 209,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -772,500.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,200,000.00 | 7,200,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **341,986,504.37** | **411,894,792.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **341,986,504.37** | **411,894,792.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 341,986,504.37 | 411,894,792.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 254,315,896.00 | 254,315,896.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 254,315,896.00 | 254,315,896.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -21,058,700.21 | 48,849,587.83 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -21,058,700.21 | -21,058,700.21 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 69,908,288.04 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 108,729,308.58 | 108,729,308.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **341,986,504.37** | **411,894,792.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **276,404,260.00** | **293,902,890.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,630,160.00** | **144,741,890.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 46,630,160.00 | 144,741,890.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 46,630,160.00 | 144,741,890.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,967,660.00 | 59,110,710.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 662,500.00 | 85,631,180.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **229,774,100.00** | **149,161,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,774,100.00 | 148,576,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,774,100.00 | 148,576,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 585,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 585,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **273,787,358.26** | **223,994,601.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **273,787,358.26** | **223,994,601.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 227,510,950.34 | 222,159,212.17 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 129,777,917.00 | 129,510,894.81 |
| 210101 | Үндсэн цалин | 129,777,917.00 | 100,418,198.09 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 24,734,696.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,158,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 200,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,609,682.90 | 16,267,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,687,329.90 | 11,061,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,297,779.00 | 1,301,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,038,222.00 | 1,041,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 235,123.00 | 260,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,351,229.00 | 2,602,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,762,893.30 | 20,628,184.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,160,573.30 | 14,873,249.90 |
| 210302 | Түлш, халаалт | 3,260,000.00 | 3,184,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,342,320.00 | 2,570,435.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,688,079.61 | 14,458,507.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,917,364.00 | 1,777,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,852,000.00 | 4,193,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,303,615.61 | 2,786,373.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 206,000.00 | 196,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,409,100.00 | 1,001,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 4,504,084.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,659,000.00 | 1,571,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,659,000.00 | 1,571,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,200,000.00 | 16,645,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 951,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 595,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,200,000.00 | 15,099,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,648,500.00 | 7,695,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,648,500.00 | 7,695,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,322,232.00 | 1,101,417.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 176,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,332.00 | 80,817.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 10,250.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,802,900.00 | 886,350.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,842,645.53 | 14,281,107.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,886,687.00 | 2,075,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 939,000.00 | 1,483,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,016,958.53 | 10,722,207.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 46,276,407.92 | 1,835,389.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,159,557.00 | 409,200.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 409,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,719,557.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 440,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,116,850.92 | 1,426,189.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,116,850.92 | 1,426,189.79 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,616,901.74** | **69,908,288.04** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,616,901.74** | **69,908,288.04** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 276,317,710.00 | 208,671,710.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 46,543,610.00 | 59,510,710.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 46,543,610.00 | 59,510,710.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 45,913,610.00 | 59,510,710.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,913,610.00 | 59,410,710.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 100,000.00 |
| 120009 | Бусад орлого | 630,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 229,774,100.00 | 149,161,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 229,774,100.00 | 148,576,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,774,100.00 | 148,576,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 585,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 276,317,710.00 | 208,671,710.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 276,317,710.00 | 208,671,710.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 230,041,302.08 | 206,836,320.21 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 140,856,076.25 | 129,510,894.81 |
| 210101 | Үндсэн цалин | 107,847,323.35 | 100,418,198.09 |
| 210102 | Нэмэгдэл | 29,459,152.90 | 24,734,696.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,549,600.00 | 4,158,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 200,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,687,860.92 | 16,267,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,409,390.41 | 11,061,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,326,633.20 | 1,301,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,061,306.57 | 1,041,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 262,775.78 | 260,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,627,754.96 | 2,602,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,762,893.30 | 20,628,184.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,160,573.30 | 14,873,249.90 |
| 210302 | Түлш, халаалт | 3,260,000.00 | 3,184,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,342,320.00 | 2,570,435.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,038,519.61 | 8,885,173.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,484,976.00 | 707,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,088,000.00 | 4,193,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,999,543.61 | 2,786,373.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 206,000.00 | 196,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,260,000.00 | 1,001,000.00 |
| 2105 | Нормативд зардал | 1,660,000.00 | 1,571,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,660,000.00 | 1,571,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,300,000.00 | 16,645,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,800,000.00 | 951,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 595,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,500,000.00 | 15,099,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,648,500.00 | 7,695,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,648,500.00 | 7,695,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,268,332.00 | 1,073,067.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 176,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 640,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 425,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,332.00 | 80,817.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 10,250.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,860,000.00 | 858,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,819,120.00 | 4,559,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,179,420.00 | 2,411,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,639,700.00 | 2,148,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,276,407.92 | 1,835,389.79 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,159,557.00 | 409,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 440,000.00 | 409,200.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,116,850.92 | 1,426,189.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,116,850.92 | 1,426,189.79 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 254,315,896.00 | 108,729,308.58 | **-23,675,601.95** | 339,369,602.63 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **254,315,896.00** | **108,729,308.58** | **-23,675,601.95** | 339,369,602.63 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **254,315,896.00** | **108,729,308.58** | **-21,058,700.21** | 341,986,504.37 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **254,315,896.00** | **108,729,308.58** | **-21,058,700.21** | 341,986,504.37 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **254,315,896.00** | **108,729,308.58** | **-21,058,700.21** | 341,986,504.37 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 69,908,288.04 | 69,908,288.04 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **254,315,896.00** | **108,729,308.58** | **48,849,587.83** | 411,894,792.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 207,922,000.00 | 207,245,520.21 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 207,922,000.00 | 207,245,520.21 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 207,512,800.00 | 206,836,320.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 130,142,400.00 | 129,510,894.81 |
| 210101 | Үндсэн цалин | 100,358,500.00 | 100,418,198.09 |
| 210102 | Нэмэгдэл | 25,425,900.00 | 24,734,696.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,158,000.00 | 4,158,000.00 |
| 210104 | Урамшуулал | 200,000.00 | 200,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,267,200.00 | 16,267,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,061,600.00 | 11,061,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,301,400.00 | 1,301,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,041,100.00 | 1,041,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 260,300.00 | 260,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,602,800.00 | 2,602,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,642,800.00 | 20,628,184.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,886,900.00 | 14,873,249.90 |
| 210302 | Түлш, халаалт | 3,184,500.00 | 3,184,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,571,400.00 | 2,570,435.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,886,900.00 | 8,885,173.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 707,800.00 | 707,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,193,400.00 | 4,193,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,778,500.00 | 2,786,373.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 196,700.00 | 196,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,010,500.00 | 1,001,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,571,000.00 | 1,571,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,571,000.00 | 1,571,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,646,200.00 | 16,645,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 951,000.00 | 951,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 595,200.00 | 595,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,100,000.00 | 15,099,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,695,900.00 | 7,695,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,695,900.00 | 7,695,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,097,600.00 | 1,073,067.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 96,500.00 | 80,817.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 19,100.00 | 10,250.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 858,000.00 | 858,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,562,800.00 | 4,559,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,414,300.00 | 2,411,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,148,500.00 | 2,148,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 409,200.00 | 409,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 409,200.00 | 409,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 409,200.00 | 409,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 207,337,000.00 | 208,086,710.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 148,576,000.00 | 148,576,000.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 148,576,000.00 | 148,576,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 58,761,000.00 | 59,510,710.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,761,000.00 | 59,410,710.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 11.00 | 11.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **585,000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **585,000.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 585,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 585000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 585000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 585,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 585,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Стандартчилал, тохирлын үнэлгээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, сорьцын хяналтын ажлын хүрээг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Байгууллага нь дараах эрх зүйн зохицуулалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

- *Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай*
- *Хэмжил зүйн тухай хууль*
- *Стандарт хэмжил зүйн газрын даргын тушаал, шийдвэр*

- *Харьяа сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*
- *Төсвийн тухай хууль*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай “*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”*

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир спортын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69.9 сая төгрөгөөр буюу 16.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 25,790.92 | 25,390.92 | 400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 14,674.08 | 10,073.40 | -4,600.68 |
| Үндсэн хөрөнгө | 301,521.49 | 376,430.46 | 74,908.97 |
| **Нийт хөрөнгө** | **341,986.50** | **411,894.79** | **69,908.29** |
| Өр төлбөр | - | - | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 254,315.89 | 254,315.89 | -- |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | -21,058.70 | 48,849.58 | 69,908.28 |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага өнгөрсөн оноос 400.0 мянган төгрөгөөр буурсан нь урт хугацааны насжилттай Мобиком ХХК-аас авах авлага 100,0 мянган төгрөг, мөн өмнө оны төлбөртэй үйлчилгээний авлага болох 300.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.
- ✓ Бараа материал 4,600.7 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын нөөцөөс 96,6 мянган төгрөгийн бараа материалыг ашиглаж, цаашид ашиглах боломжгүй 4,504.1 мянган төгрөгийн бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу данснаас хассантай холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө 69,908.2 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээгээр 67,424.6 мянган төгрөг, цаашид ашиглах боломжгүй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 10,356.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, мөн Стандарт хэмжил зүйн газраас 18,206.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны улсын төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 148,6 сая төгрөг, өөрийн орлогоос 58.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 148.6 сая төгрөг, өөрийн орлогоос 59.5 сая төгрөг нийт 208.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 206.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйл ажиллагаа зардалд зарцуулж, 1.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70407/80101-үндсэн үйл ажиллагааны зардал | 208,671.7 | 207,245.5 | 1,426.2 | 99 |
| **ДҮН** | | **208,671.7** | **207,245.5** | **1,426.2** | **99** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 585.0 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаагаа явуулжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 15 -наас 02 дугаар сарын 24–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 223.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс 159 мэдээллийг цаг хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгийн, мөнгө зарцуулах 4 шийдвэртэй холбоотой 5.1 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цэст байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээ хийгдсэнээс 12 гүйлгээг нэгдсэн цэст мэдээлсэн байна.

**4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар Шүүхийн шийдвэртэй ажилтны цалинг байгууллагын төсвөөс олгосонтой холбоотой 15.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, хөрөнгийн ашиглалттай холбоотой 13.4 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгджээ.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 15020.9 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 1 | 13,445.7 | 1 | 13,445.7 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **28,466.6** | **1** | **13445.7** | **50.0** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар өнгөрсөн оны аудитаар тавигдсан төлбөрийн актыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгааг биелэлтэд нь анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа[1] илрээгүй.

Харин 9.1 төгрөгийн зөрчил[2] илэрсэнд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

#### *5.1.1 Шилэн данстай холбоотой асуудал.*

*Илрүүлэлт* Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс 159 мэдээллийг цаг хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгийн, мөнгө зарцуулах 4 шийдвэртэй холбоотой 5.1 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цэст байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д" Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ" хуулийн заалтыг зөрчсөн байна

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Өгсөн зөвлөмж* Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаж хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг бүрэн байршуулж байх

### *5.1.2 Бараа материалтай холбоотой асуудал .*

*Илрүүлэлт* Тайлант онд тухайн байгууллагын албан конторын болон гражийн дээврийн засвар хийсэн "ЗА-ТУС" ХХК-ны 9.1 сая засварын аж ахуйн материал, худалдан авсан шатахуун зэрэг бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа "И" баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.
Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж* Худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг "И" баримтаар баталгаажуулан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая.төгрөг/

| Зөрчлийн товч утга | Үнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт алдаа | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилт | 1 | - | | | | | 1 | - |
| Бараа материалтай холбоотой асуудал | 1 | 9.1 | | | | | 1 | 9.1 |
| Нийт дүн | 2 | 9.1 | | | | | 2 | 9.1 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:** **Ц.ГАНТУЛГА**